



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/367

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Худалдах доод үнэ шинэчлэн тогтоох тухай” А/345 дугаар захирамжийн дагуу 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн автомашины дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

Хөтлөгч: С.Даваадоньд (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Б.Даваадолгор (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын архив, бичиг хэргийн ажилтан)

Гишүүд: Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Сайнбилэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

2. Дуудлага худалдааг хуулийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Г.Ариунаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100789